



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 02 өдөр

Дугаар Б/130

Улаанбаатар хот

Ц.Бямбасүрэнд цалинтай чөлөө,
буцалтгүй тусламж олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжаар батлагдсан “Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дүрэм”-ийн 2.5.3, Хөдөлмөрийн дотоод журмын 6.14, 7.3.12-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Цэндбазарын Бямбасүрэнгийн гаргасан өргөдөл, нөхрийн эрүүл мэндийн шалтгаан, ар гэрийн аргагүй байдлыг харгалзан үзэж 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн ажлын 22 хоногийн цалинтай чөлөө, нэг удаагийн буцалтгүй тусламж 1,000,000 төгрөг /Нэг сая/ -ийг тус тус олгосугай.

2. Буцалтгүй тусламжийн зардал 1,000,000 төгрөг /Нэг сая/ -ийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалын зардлаас тооцож олгохыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Ахлах нягтлан бодогч /Э.Эрдэнэтуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Ц.Бямбасүрэнгийн албан тушаалын чиг үүргийг хэвийн явуулахад анхаарч, зохион байгуулалтын арга хэмжээ авч, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /М.Мөнхбаяр/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР